



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/136

Булган сум

Төрийн их хүндэтгэлийн Морин хуур
худалдан авахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай 2024 оны 09 дүгээр зарлиг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн төрөлхтний соёлын биет бус өв, монгол үндэсний бахархал болох морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Төрийн захиргааны төв байгууллагад хүндэтгэн залах мастер морин хуур худалдан авахад 4,700,000 (дөрвөн сая долоон зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010175